



**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар A/35

Улаанбаатар хот

Дүүргийн ерөнхий боловсролын
сургуулиудад хүүхдийн автобус хүлээн
авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Хүүхдийн автобусны үйлчилгээг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай” А/110 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлсэн хүүхдийн сургуулийн автобус төслийн хүрээнд нийлүүлэгдэх Dongfeng EQ6100ST6D1 загварын 2 (хоёр) ширхэг автобусыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Балжинням

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Г.Гэрэлмаа

(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)

Д.Дэмчигжав

(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга)

Н.Алтансүх

(Боловсролын хэлтсийн дарга)

Б.Буянхишиг

(Боловсрол цогцолбор сургуулийн захирал)

З.Болормаа

(Гүн галуутай цогцолбор сургуулийн захирал)

Б.Оюунбаатар

(Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ-ын дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Алтангэрэл

(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

2.Дээрх төслөөр ирж буй автобусаар зорчих шаардлагатай хүүхдийн тоо, судалгаа гаргах, үйлчилгээний чиглэлийг тогтоох, тээврийн хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, засвар, үйлчилгээ, тээвэрлэлтийг зохих стандартын шаардлагыг хангуулан зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Балжинням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red square official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is stylized and extends across the stamp.

С.ДАВААСҮРЭН